

МОНГОЛ ДАХЬ ДИЖИТАЛ ХҮМҮҮНЛЭГИЙН БОЛОВСРОЛЫН ТУХАЙ

(Уран зохиолын жишээн дээр)

П.Яньдий¹

Дижитал хүмүүнлэгийн ухаан нь компьютерийн шинжлэх ухаан, хүмүүнлэгийн ухааны гүн гүнзгий интеграцчлалаас гаралтай салбар юм. Өөрөөр хэлбэл дижитал хүмүүнлэгийн ухаан нь уран зохиол, түүх, гүн ухаан зэрэг уламжлалт хүмүүнлэгийн салбаруудад тооцоолох арга хэрэгслийг ашиглахтай холбоотой үүссэн шинэ салбар юм.

Энэ салбар нь дижитал арга, янз бүрийн соёлын огтлолцлыг судалгааны объект болгон авч тоон аргыг хүмүүнлэгийн ухаантай хослуулах бүх хууль тогтоомж, хэрэглээний аргуудыг системтэйгээр судалдаг байна.

Орчин үеийн нийгэмд мэдээллийн нийгэм, цахим технологийн зуун, мэдээллийн даяар сүлжээ болох интернэт, виртуаль бодит байдал, тоон хувьсгал зэрэг үг хэллэг түгээмэл хэрэглэгдэх болсон нь энэ үеийн иргэншлийн соёлын орон зай дахь шинэ өнгө төрх, голлох шинж тэмдгүүд юм. Энэ мэт үг хэллэг бидний амьдралын хэв маягт ямархуу өөрчлөлт шинэчлэлт буй болсоор буйг тодорхой харуулж байна.

Дэлхийн олон орны эрдэмтэн, сэтгэгчид XXI зууны энэ үеийг “Дижитал технологийн хувьсал, хөгжлийн эрин цаг” хэмээн нэрлэдэг.² Энэхүү техник технологийн хурдтай хөгжиж буй өнөө үед боловсролын салбарт тэртусмаа уран зохиолын салбарт дижитал уран зохиол хэмээх ойлголт буй болсоор тодорхой хугацаа өнгөрчээ.

Дижитал уран зохиол гэдэг нь тодорхойгүй ойлголт бөгөөд хэнээс асуухаас хамаарч ухагдахуун нь өөрчлөгддөг гэж үздэг. Зарим нь үүнийг дижитал хэлбэрээр үүсэгсэн бичвэрүүдээс бүрддэг бөгөөд ихэвчлэн компьютер дээр уншихад зориулагдсан бүтээл гэж үздэг бол цахим уран зохиолын хувьд дижитал уран зохиол гэдэг нь “бие даасан эсвэл сүлжээнд холбогдсон компьютерийн боломж нөхцлийг ашиглан уран зохиолын чухал гэж үзсэн хэсэг дээр ажиллахыг хэлдэг” гэжээ. Тэгвэл Зохиолч Саймон Гротос дижитал уран зохиол гэж “технологид суурилсан орчин үеийн уран зохиолыг “ хэлнэ гэсэн байдаг. Энэ бүгдээс харахад дижитал уран зохиол гэдэг ойлголтын хамгийн гол бүрэлдэхүүн хэсэг нь технологийн хэрэглээ болох нь харагдаж байна. Энэ утгаараа үндсэндээ уран зохиолын шинэ хэрэгсэл төдийгүй ямар уран зохиолыг дижитал уран зохиолд хамааруулж болох вэ? гэсэн асуулт урган гарч ирж байна.

Судалгааны бүтээлүүдэд цахим ном, цахим текст, цахим контент гэх мэт зүйлсийг дижитал уран зохиолд хамруулдаггүй агаад үүнийг дижитал медиа ба текстийн огтлолцол гэж үздэг ажээ. Тэгэхээр компьютер дээрээ роман бичээд хэвлүүлвэл энэ нь дижитал уран зохиол болдоггүй байна. Харин твиттер, хайпертекст, видео гэх мэт платформ хэлбэрээр

¹ МУБИС, НХУС, Утга зохиолын тэнхим. Доктор (Ph.D)

² Мөнхбаяр. Б., Уран зохиолын дижитал сэтгэлгээ хэмнэл ба хэлбэр. 1-р тал

буй бүтээлүүдийг дижитал уран зохиолд хамааруулдаг байна. Энэ бүхнийг бид монголын уран зохиолын жишээн дээр тодруулан авч үзэх болно.